

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



АУДИТЫН ТАЙЛАН

Нийслэлийн Сүхбаатар дүүргийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: НТАГ-2026/004/НА-СТА-ТТЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он</p>	<p>Нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Г.Нандинжаргал Утас: 70007734 Цахим хаяг: nandinjargalg@audit.gov.mn</p> <p>Санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер: Х.Түвшинбаяр Утас: 315558 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Д.Отгонбаяр Утас: 315558 Цахим хаяг: otgonbayarda@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: М.Ундармаа Утас: 325093 Цахим хаяг: undarmaam@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	5
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.5 Аудит хийсэн нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	7
2.6 Аудит хийсэн нэгдсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	10
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	13

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2026.03.25 № 1018

танай _____-ны № _____-т

НИЙСЛЭЛИЙН СҮХБААТАР
ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГА
М.АЛТАНГЭРЭЛ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Нийслэлийн Сүхбаатар дүүргийн Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон нэгдсэн төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд 649,789.0 сая төгрөгийг дүүргийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 619,922.1 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөө 4.6 хувиар тасарсан байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд 720,919.7 сая төгрөгийн төсөв баталсан бөгөөд түүнд 1 удаа тодотгол хийж, 1,785.4 сая төгрөг буюу 0.3 хувиар нэмэгдүүлэн, 722,705.1 сая төгрөгөөр баталжээ. Үйл ажиллагаандаа 644,449.1 сая төгрөгийн төсөв зарцуулсан нь өмнөх онтой харьцуулахад 12.9 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Бусад асуудал

Нийслэлийн Сүхбаатар дүүргийн Засаг даргын 2025 оны үйл ажиллагааны хөтөлбөрт 5 зорилт, 13 зорилгын хүрээнд 227 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 94.1 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн нэгтгэсэн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, нэгдсэн төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн нэгтгэсэн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		148,731,682.7	157,464,856.1
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	83,874,131.9	62,828,627.3
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	816,912.8	1,362,910.3
34	УРЬДЧИЛГАА	7а, 7б	770,571.3	860,857.6
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	2,222,972.5	4,651,590.4
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	10	61,047,094.2	87,760,870.5
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		105,433,937.2	118,375,634.9
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	105,433,937.2	118,375,634.9
39200	Биет хөрөнгө		100,715,893.9	113,667,844.4
39300	Биет бус хөрөнгө	13	4,718,043.3	4,707,790.5
39400	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	14	-	-
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		254,165,619.9	275,840,491.0
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		9,247,788.8	11,109,224.4
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	7,069,704.9	6,847,015.6
41300	Өглөг	17а, 17б	6,453,726.4	5,774,504.9
41400	Урьдчилж орсон орлого	18а, 18б	615,978.5	1,072,510.7
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		2,178,083.9	4,262,208.8
42200	Урт хугацаат зээл	20а, 20б	2,178,083.9	4,262,208.8
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		244,917,831.1	264,731,266.6
51	Засгийн газрын хувь оролцоо		244,917,831.1	264,731,266.6
51100	Засгийн газрын оруулсан капитал		34,492,003.5	124,359.8
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/		577,213.2	34,944,857.0
51106	Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/			
51200	Хуримтлагдсан үр дүн		174,713,548.1	194,577,136.2
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		35,135,066.3	35,084,913.6
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		254,165,619.9	275,840,491.0

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон			/мянган төгрөгөөр/	
Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		559,764,831.3	637,871,422.1
11	ТАТВАРЫН ОРЛОГО		530,160,941.0	603,135,341.4
110	Орлогын албан татвар		478,984,274.7	546,846,329.2
1100	Хувь хүний орлогын албан татвар		478,984,274.7	546,846,329.2
113	Хөрөнгийн албан татвар		30,354,249.8	31,411,375.1
118	Бусад татвар, төлбөр, хураамж		20,822,416.5	24,877,637.1
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	20,635,286.9	34,736,080.7
120	Нийтлэг татварын бус орлого		19,299,368.2	32,261,318.6
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг		1,335,918.7	1,088,625.1
122	Тусламжийн орлого		-	1,386,137.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		8,968,603.4	-
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	507,380,760.2	612,937,566.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ		507,380,760.2	604,649,948.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		117,889,766.1	124,097,134.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		10,751,008.8	13,213,794.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		1,191,260.5	1,797,769.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		7,228,217.7	9,342,549.5
2104	Хангамж, бараа материалын зардал		7,006,217.7	7,681,396.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		8,408,712.6	6,689,732.8
2107	Томилолт, зочны зардал		1,450,736.0	751,422.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		62,455,326.1	64,095,593.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		19,398,286.7	20,524,876.5
212	ТАТААС		196,981.2	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		389,294,012.9	480,552,814.0
	хөрөнгийн зардал		-	8,287,618.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		52,384,071.1	24,933,855.5
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		18,589,878.5	5,124,690.1
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		33,794,192.6	19,809,165.4

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон		/мянган төгрөгөөр/	
Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	211,306,220.3	211,306,220.3
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(181,291.4)	(181,291.4)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	211,124,928.9	211,124,928.9
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(1,290.4)	(1,290.4)
7	Өмчид гарсан өөрчлөлт		
9	Тайлант үеийн үр дүн	33,794,192.6	33,794,192.6
10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	244,917,831.1	244,917,831.1
11	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	244,917,831.1	244,917,831.1
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	54,422.6	54,422.6
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	244,972,253.7	244,972,253.7
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(50,152.6)	(50,152.6)
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт		
17	Өмчид гарсан өөрчлөлт		
19	Тайлант үеийн үр дүн	19,809,165.5	19,809,165.5
20	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	264,731,266.6	264,731,266.6

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон		/мянган төгрөгөөр/	
Код:	Тайлангийн үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	558,432,599.5	630,042,760.2
11	ТАТВАРЫН ОРЛОГО	530,160,941.0	603,135,341.4
110	Орлогын албан татвар	478,984,274.7	546,846,329.2
1100	Хувь хүний орлогын албан татвар	478,984,274.7	546,846,329.2
113	Хөрөнгийн албан татвар	30,354,249.8	31,411,375.1
118	Бусад татвар, төлбөр, хураамж	20,822,416.5	24,877,637.1
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	16,000,284.5	19,632,265.2
1181	Газрын төлбөр	4,821,055.7	5,245,371.9
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	1,076.3	-
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	19,303,055.1	26,907,418.8
120	Нийтлэг татварын бус орлого	17,967,136.4	24,432,656.9
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	1,335,918.7	1,088,625.0
122	Тусламжийн орлого		1,386,136.9
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	8,968,603.4	-
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	475,216,774.1	577,379,721.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	475,216,774.1	577,379,721.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	85,714,912.8	96,841,788.6

**Нийслэлийн Сүхбаатар дүүргийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан**

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	20,152,674.4	27,101,065.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,529,587.3	4,747,769.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	7,391,273.1	9,596,551.2
2104	Хангамж, бараа материалын зардал	10,408,559.2	10,647,080.6
2105	Норматив зардал	1,310.0	1,189.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,469,806.3	6,855,682.1
2107	Томилолт, зочны зардал	1,222,777.2	1,048,360.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	27,324,529.0	30,626,810.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,214,396.3	6,217,279.7
212	ТАТААС	196,981.2	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	389,304,880.1	480,537,932.8
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	83,215,825.4	52,663,038.8
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	77,644,715.8	73,708,543.5
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	77,644,715.8	73,708,543.5
2200	Дотоод эх үүсвэрээр	77,644,715.8	73,708,543.5
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(77,644,715.8)	(73,708,543.5)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	5,571,109.8	(21,045,504.6)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	78,303,022.1	83,874,131.9
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	83,874,131.9	62,828,627.3

2.5 Аудит хийсэн нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	722,705,090.0	644,449,146.0	78,255,944.0	89.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	602,775,539.5	576,315,649.9	26,459,889.6	95.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	121,700,472.3	95,817,717.1	25,882,755.2	78.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	16,495,154.7	13,210,992.8	3,284,161.9	80.1
210101	Үндсэн цалин	7,147,213.0	5,347,729.1	1,799,483.9	74.8
210102	Нэмэгдэл	1,660,168.4	1,702,896.6	(42,728.2)	102.6
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,060,840.3	1,621,685.7	439,154.6	78.7
210104	Урамшуулал	719,374.6	376,812.8	342,561.8	52.4
210105	Гэрээт ажлын хөлс	4,907,558.4	4,161,868.6	745,689.8	84.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,161,547.9	1,254,652.6	906,895.3	58.0
210201	Тэтгэврийн даатгал	1,276,244.9	798,505.1	477,739.8	62.6
210202	Тэтгэмжийн даатгал	238,931.0	131,957.3	106,973.7	55.2
210203	ҮОМШӨ-ний даатгал	190,064.6	82,225.0	107,839.6	43.3
210204	Ажилгүйдлийн даатгал	156,966.3	79,551.7	77,414.6	50.7

**Нийслэлийн Сүхбаатар дүүргийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан**

210205	Эрүүл мэндийн даатгал	299,341.1	162,413.5	136,927.6	54.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,787,892.3	9,342,549.5	10,445,342.8	47.2
210301	Гэрэл, цахилгаан	7,403,117.9	4,238,270.1	3,164,847.8	57.2
210302	Түлш, халаалт	7,288,473.5	3,702,802.7	3,585,670.8	50.8
210303	Цэвэр, бохир ус	4,817,936.4	1,296,561.7	3,521,374.7	26.9
210304	Байрны түрээс	278,364.5	104,915.0	173,449.5	37.7
2104	Хангамж, бараа материалын зардал	30,047,902.7	28,700,302.3	1,347,600.4	95.5
210401	Бичиг хэрэг	128,020.0	123,748.0	4,272.0	96.7
210402	Тээвэр, шатахуун	108,400.0	80,947.1	27,452.9	74.7
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	150,180.0	129,213.4	20,966.6	86.0
210404	Ном хэвэлэл	140,524.5	63,772.8	76,751.7	45.4
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	29,345,435.8	28,184,886.8	1,160,549.0	96.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	175,342.4	117,734.2	57,608.2	67.1
2105	Норматив зардал	109,928.0	1,189.0	108,739.0	1.1
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	7,000.0	-	7,000.0	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	102,928.0	1,189.0	101,739.0	1.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,759,665.6	11,145,469.2	1,614,196.4	87.3
210601	Багаж, техник, хэрэгсэл	330,175.0	115,677.9	214,497.1	35.0
210602	Тавилга	243,875.0	5,468.1	238,406.9	2.2
210604	Урсгал засвар	12,185,615.6	11,024,323.2	1,161,292.4	90.5
2107	Томилолт, зочны зардал	1,182,846.8	1,048,360.6	134,486.2	88.6
210701	Гадаад албан томилолт	449,746.8	344,574.3	105,172.5	76.6
210702	Дотоод албан томилолт	27,550.0	2,550.0	25,000.0	9.3
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	705,550.0	701,236.3	4,313.7	99.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	31,100,548.3	24,589,116.7	6,511,431.6	79.1
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	30,864,406.8	24,498,666.5	6,365,740.3	79.4
210802	аудит баталгаажуулалт	2,591.5		2,591.5	-
210803	Даатгалын үйлчилгээ	32,500.0	7,468.0	25,032.0	23.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	11,350.0	2,289.4	9,060.6	20.2
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	10,100.0	110.0	9,990.0	1.1
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	52,000.0	15,400.0	36,600.0	29.6
210807	Газрын төлбөр	127,600.0	65,182.8	62,417.2	51.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,054,986.0	6,525,084.5	1,529,901.5	81.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,856,746.0	6,441,175.7	1,415,570.3	82.0

**Нийслэлийн Сүхбаатар дүүргийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан**

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	198,240.0	83,908.8	114,331.2	42.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	481,075,067.2	480,497,932.8	577,134.4	99.9
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	479,513,551.8	479,478,551.8	35,000.0	100.0
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	479,513,551.8	479,478,551.8	35,000.0	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,561,515.4	1,019,381.0	542,134.4	65.3
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	12,000.0	800.0	11,200.0	6.7
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	15,000.0	13,868.8	1,131.2	92.5
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	309,515.4	69,569.9	239,945.5	22.5
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,225,000.0	935,142.3	289,857.7	76.3
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	119,929,550.5	68,133,496.1	51,796,054.4	56.8
220001	Барилга байгууламж	58,502,630.9	27,587,060.7	30,915,570.2	47.2
221001	Их засвар	30,297,378.1	21,212,130.0	9,085,248.1	70.0
222001	Тоног төхөөрөмж	6,347,793.9	4,044,055.6	2,303,738.3	63.7
223001	Бусад хөрөнгө	24,781,747.6	15,290,249.8	9,491,497.8	61.7
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	722,705,090.0	644,449,146.0	78,255,944.0	89.2
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,099,080.0	1,088,625.0	10,455.0	99.0
310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	1,099,080.0	1,088,625.0	10,455.0	99.0
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	721,564,510.0	643,240,569.5	78,323,940.5	89.1
320001	Орон нутгийн төсвөөс	721,564,510.0	643,240,569.5	78,323,940.5	89.1
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	41,500.0	119,951.5	(78,451.5)	289.0
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	41,500.0	84,807.5	(43,307.5)	204.4
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих		35,144.0	(35,144.0)	
	Харилцах хадгаламжийн цэвэр өөрчлөлт	72,916,131.8	24,397,388.7	(24,397,388.7)	33.5
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	74,446,075.8	(74,446,075.8)	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	50,048,687.1	(50,048,687.1)	
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	597.0	566.0	31.0	94.8
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	9.0	9.0	-	100.0
610001	Төсвийн байгууллага	5.0	5.0	-	100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	597.0	566.0	31.0	94.8
620001	Удирдах ажилтан	39.0	39.0	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	212.0	190.0	22.0	89.6
620003	Үйлчлэх ажилтан	45.0	37.0	8.0	82.2
620004	Гэрээт ажилтан	301.0	300.0	1.0	99.7
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	597.0	566.0	31.0	94.8

**Нийслэлийн Сүхбаатар дүүргийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан**

650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	139.0	137.0	2.0	98.6
650002	Төрийн тусгай албан хаагч (ТТ)	7.0	7.0	-	100.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	77.0	70.0	7.0	90.9
650010	Гэрээт ажилтан	301.0	300.0	1.0	99.7
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	73.0	52.0	21.0	71.2

2.6 Аудит хийсэн нэгдсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон		/мянган төгрөгөөр/
Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	15,145,488.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	14,604,012.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	985.0
210406	Хангамж, бараа материалын зардал	985.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,560,027.2
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	14,560,027.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	43,000.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,000.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	40,000.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	40,000.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	40,000.0
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	541,476.3
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	541,476.3
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	15,145,488.5
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	15,145,488.5
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	5,342.7
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,005,812.2
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	14,115,906.9
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	18,426.7

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж гаргалаа.

Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 5 төсвийн байгууллага, сан, зардал, 3 ОНӨААТҮГ-ын санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 7 байгууллага, сан, зардал аудитад хамрагдсан. Үүнд: Орон нутгийн төсвийн 5 байгууллага *ИТХ, ЗДТГ, Худалдан авах ажиллагааны алба, Дотоод аудитын алба, Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төв*, 2 сан, зардал *IONХС, Дүүргийн хөрөнгө оруулалтын*

зардал/, 2 ОНӨААТҮГ / Сүхбаатар дэвшил ОНӨААТҮГ, Сүхбаатар дэвшил менежмент ОНӨААТҮГ/-ын санхүүгийн тайланг хамруулж, аудитын горим, сорилыг хэрэгжүүлсэн. Сүхбаатар дүүргийн Багахандагайт ОНӨААТҮГ тайлант онд үйл ажиллагаа явуулаагүй тул аудитад хамрагдаагүй.

Санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэрийг дараах хүснэгтээр үзүүлэв.

№	Байгууллагын ангилал	НТАГ-аас дүгнэлт гаргасан	Аудитын хуулийн этгээдээр гэрээгээр хийлгэж дүгнэлт гаргасан	Үе шатны ажлыг хэсэгчлэн хийсэн	Аудитад хамрагдаагүй
1	ТШЗ	2	-	5	-
2	ОНӨААН	1	1	-	1
	Дүн	3	1	5	1

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын 7 санхүүгийн тайланд “Зөрчилгүй” (дүүргийн ЗДТГ, ИТХ, Сүхбаатар дэвшил ОНӨААТҮГ, Сүхбаатар дэвшил менежмент ОНӨААТҮГ) санал дүгнэлт өгсөн.

3.1 Санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Нийслэлийн Сүхбаатар дүүргийн Засаг даргын эрхлэх хүрээний харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 6,020.6 мянган төгрөгийн алдаа илэрснийг аудитын явцад залруулж, 59,020.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 545,783.3 мянган төгрөгийн 19 албан шаардлага хүргүүлж, 372,557.7 мянган төгрөгийн 26 зөвлөмж өгсөн.

3.2 Төсвийн төвлөрүүлэн захирагч

Аудитаар Төсвийн тухай хуулийг мөрдөж ажиллах 161,211.6 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, хариуцлага тооцуулах 1 албан шаардлага, Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийг мөрдөн ажиллах 3,397,727.1 мянган төгрөгийн 1 зөвлөмжийг хүргүүллээ.

3.2.1 Төлбөрийн акт

Илрүүлэлт: Хөрөнгө оруулалтын ажлуудын ажил гүйцэтгэх гэрээний тусгай нөхцөлд заасан 161,211.6 мянган төгрөгийн барьцааны хугацаа дууссан үлдэгдлийг гүйцэтгэгч аж ахуйн нэгж байгууллагуудад буцаан олгоогүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7-д “Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ”, Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.8-д “Улс, орон нутгийн төсөв, гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх барилга байгууламжид энэ хуулийн 14.3-т заасан хугацаанд гүйцэтгээгчээс хүлээсэн үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор гэрээний үнийн дүнгийн тодорхой хувийг уг хугацаа дуустал барьцаалах нөхцөлийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 42.6-д заасны дагуу зохицуулна”, 14.3-т “Барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаа нэг жил байна”, 14.6-д “Энэ хуулийн 14.3-т заасан хугацаа дуусгавар болсноос хойш барилга байгууламжийн гадна, дотор засал, бүх төрлийн материал, үндсэн хийц, бүтээц, цэвэр, бохир ус, уур, хий, дулаан, цахилгаан, харилцаа холбооны тоног төхөөрөмж, тоноглолын хэвийн ашиглалтын хугацаа гурваас доошгүй жил байна” гэж заасантай нийцээгүй,

санхүүгийн тайлагналын “*нийцсэн бөгөөд зохистой байх*” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хугацаа дууссан барьцааны үлдэгдлийг дүүргийн ерөнхий орлогын дансанд төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

3.2.2 Албан шаардлага

Илрүүлэлт: Нэмэлт санхүүжилтийн данснаас зориуд нэр данс зөрүү гэх утгаар 172,382.1 мянган төгрөгийн гүйлгээг гаргасан, төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулсан, өмнөх оны аудитын шийдвэрийг бүрэн биелүүлээгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “*батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;*” 41 дүгээр зүйлийн 41.1-д “*Төсвийн сахилга батыг хангаж, хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулахгүй тайлагнах*”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-д “*хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх*”, Зөрчлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.6-д “*төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулсан, тайлагнаагүй тохиолдолд хариуцлага хүлээлгэх*”; 11 дүгээр зүйлийн 11.19-д “*нягтлан бодох бүртгэлийг буруу хөтөлсөн, санхүүгийн тайланг зөрчилтэй гаргасан тохиолдолд хариуцлага хүлээлгэх*” гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын “*нийцсэн бөгөөд зохистой байх*” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Гүйлгээг зориуд нэр данс зөрүү гэх утгаар гаргахад хяналт хэрэгжүүлээгүй баталсан, төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулсан зөрчлийг зогсоож, давтан гаргахгүй байх эрх бүхий албан тушаалтанд хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлэв.

3.2.3 Зөвлөмж

Илрүүлэлт: 2 дугаар цэцэрлэгийн өргөтгөлийн барилгын ажлыг 2025 оны 01-р сарын 09-ны өдөр хүлээлгэн өгөхөөр гэрээлсэн байтал 2024 онд төсөвт өртгийн 59 хувийг олгосон. Гэрээг 2 удаа үндэслэлгүй сунгасан нь Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.1-д “*захиалагч урьдчилан харах боломжгүй гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас болон гэрээнд заасан үндэслэлээр гэрээний үүрэг гүйцэтгэх хугацааг сунгах*” гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын “*нийцсэн бөгөөд зохистой байх*” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Гэрээний хугацаа сунгах шалтгааныг нарийвчлан судалж, шийдвэрлэж хэвших, шаардлагатай тохиолдолд захиалагчийн зүгээс гэрээг цуцлах, алданги ногдуулах зэрэг арга хэмжээ авах,

Дээрх албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг Нийслэл дэх Төрийн аудитын газарт 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү. Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/ Үүнээс Залруулсан	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
							Тоо	Дүн
СБДМ ОНӨААТҮГ	2	6,020.6			2	6,020.6	2	6,020.6
ОНӨААНБ-ын дүн	2	6,020.6			2	6,020.6	2	6,020.6

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/ Үүнээс:					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
СБД ЗД	3	3,558,939.3	1	161,211.6	1	-	1	3,397,727.7
СБД ИТХ	5	88,989.7			2	49,200.0	3	39,789.7
СБД ЗДТГ	5	723,171.3			3	488,374.8	2	234,796.5
СБД ХАА	3	3,612.5					3	3,612.5
СБД ЖДҮДТ	2	52,799.5					2	52,799.5
СБД ДАА	1	10,858.7					1	10,858.7
Орон нутгийн байгууллагын дүн	19	4,438,370.9	1	161,211.6	6	537,574.8	12	3,739,584.5
СБД ОНӨААТҮГ	1	59,020.0	1	59,020.0				
СБДМ ОНӨААТҮГ	4	38,909.5			1	8,208.5	3	30,700.9
ОНӨААНБ-ын дүн	5	97,929.5	1	59,020.0	1	8,208.5	3	30,700.9
НИЙТ ДҮН	24	4,536,300.4	2	220,231.6	7	545,783.3	15	3,770,285.4

Нийслэлийн Сүхбаатар дүүргийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
СБД ЖДҮДТ	1	3,408.4					1	3,408.4
Орон нутгийн байгууллагын дүн	1	3,408.4			0		1	3,408.4
СБД ОНӨААТҮГ	1				1	-	0	
ОНӨААНБ-ын дүн	1				1		0	
Дүн	2	3,408.4			1	-	1	3,408.4
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
СБД ИТХ	1	-					1	-
СБД ЗДТГ	4	634,480.6			3	614,680.6	1	19,800.0
СБД ЖДҮДТ	2	9,949.2					2	9,949.2
Орон нутгийн байгууллагын дүн	7	644,429.8			3	614,680.6	4	29,749.2
СБД ОНӨААТҮГ	1	677,539.7			1	677,539.7		
ОНӨААНБ-ын дүн	1	677,539.7			1	677,539.7		
Дүн	8	1,321,969.5			4	1,292,220.3	4	29,749.2
Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
СБД ИТХ	5	317,117.0	1	700.0	3	304,312.0	1	12,105.0
СБД ЗДТГ	2	502,404.8			2	502,404.8		
СБД ЖДҮДТ	1	1,189.0					1	1,189.0
Орон нутгийн байгууллагын дүн	8	820,710.8	1	700.0	5	806,716.8	2	13,294.0
СБДМ ОНӨААТҮГ	1	17,563.6			1	17,563.6	0	
ОНӨААНБ-ын дүн	1	17,563.6			1	17,563.6	0	
Дүн	9	838,274.4	1	700.0	6	824,280.4	2	13,294.0
НИЙТ ДҮН	19	2,163,652.3	1	700.0	11	2,116,500.7	7	46,451.6